

МОНГОЛ УЛСАД ЭМЧЛЭХ БОЛОМЖГҮЙ ӨВЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР 2024-2025 ОНД
СУРАЛЦСАН БАГУУД

Д/д	Өвчний нэр, эмчилгээний нэр төрөл	Гадаад сургалтад хамрагдсан багуудын мэдээлэл
А.	Мэдрэлийн мэс засал	
1.	Тархи нугасны гүний, төвөгтэй байрлалтай, нэвчсэн, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал, эмчилгээ	Байгууллага: УГТЭ Багийн бүрэлдэхүүн: 3 хүн – 2 мэдрэлийн мэс заслын эмч, 1 мэдрэлийн мэс сувилагч Суралцсан улс, байгууллага: БНТУ, Чок их сургуулийн эмнэлэг, Истанбулын Америк эмнэлэг Сургалтын хугацаа: 2 сар, 2024.11.18 - 2025.01.17 Байгууллага: ХСҮТ Суралцсан чиглэл: Нейронавигацийн систем, нейромониторийг ашиглан тархины гүний төвөгтэй байрлалтай, гавлын суурийн хэсгийн хавдрын мэс засал эмчилгээ Багийн бүрэлдэхүүн: 5 хүн - 3 мэдрэлийн мэс заслын эмч, 1 мэдээгүйжүүлгийн эмч, 1 эрчимт эмчилгээний эмч, 1 хими эмчилгээний эмч Суралцсан улс, байгууллага: БНХАУ, Чанжоугийн Ардын Эмнэлэг Сургалтын хугацаа: 3 сар, 2024.12.23 - 2025.03.22
2.	Паркинсоны өвчин, торсион дистонид стереотакс мэс заслын аргаар тархины гүнийн өдөөлт хийн, электрод суулгах эмчилгээ	
Б.	Чих хамар хоолой судлал	
3.	Сонсголын мэдрэлийн хавдрын үеийн мэс засал	
4.	Вегенерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн эмчилгээ	
5.	Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс засал эмчилгээ	Сургалт цуцлагдсан: Олон Улсын түвшинд тус өвчлөлийг мэс заслын аргаар эмчлэх нь хоцрогдсон тул БНСУ, БНТУ, БНХАУ, БНЭУ

		болон Япон Улсуудад тус багийг хүлээж авах боломжгүй талаар хариу ирүүлсэн.
В.	Зүрх, судасны мэс засал	
6.	Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээ	Байгууллага: УХТЭ Багийн бүрэлдэхүүн: 5 хүн – 3 зүрх судасны их эмч, 1 сувилагч, 1 дүрс оношилгооны техникч Суралцсан улс, байгууллага: БНХАУ, И да эмнэлэг Сургалтын хугацаа: 2 сар, 2024.10.10-2024.12.15
7.	Хүүхдийн хавсарсан хөх, хүнд хэлбэрийн зүрхний төрөлхийн гажгийн үеийн мэс засал эмчилгээ	Байгууллага: ЭХЭМҮТ Багийн бүрэлдэхүүн: 8 хүн – 2 зүрхний мэс заслын эмч, 2 мэдээгүйжүүлгийн эмч, 1 эрчимт эмчилгээний эмч, 3 сувилагч Суралцах улс, байгууллага: БНХАУ, Фудан Их сургуулийн хүүхдийн эмнэлэг Сургалтын хугацаа: 1 сар, 2 сар, 5 сар, 2025.04.02 – 2025.09.13
8.	Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулралын эмчилгээ	Байгууллага: УГТЭ Багийн бүрэлдэхүүн: 4 хүн – 2 зүрх судасны мэс заслын эмч, 2 мэс заслын сувилагч Суралцсан улс, байгууллага: БНСУ, Йонсэй Их сургуулийн Северанс эмнэлэг Сургалтын хугацаа: 1 сар, 2024.12.15 - 2025.01.17
9.	Зүрхний хавхлагуудын өөрчлөлт, кардиомиопати, зүрхний хүнд хэлбэрийн хэм алдагдлын улмаас зүүн ховдлын агших чадвар 25 хувиас доош болсон тохиолдлын эмчилгээ	
10.	Хүүхдийн зүрхний хэм алдагдлын үеийн электрофизиологийн оношилгоо, эмчилгээ	Байгууллага: ЭНЭҮТ Багийн бүрэлдэхүүн: 5 хүн – 2 зүрх судас, ангиографийн эмч, 1 дүрс оношилгооны техникч, 1 мэдээгүйжүүлгийн эмч, 1 сувилагч Суралцсан улс, байгууллага: БНЭУ, Сарвадоя эмнэлэг

		Сургалтын хугацаа: 1 сар, 2024.09.23 - 2024.10.20
Г.	Хавдар судлал	
11.	Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс заслын эмчилгээ	Байгууллага: ХСҮТ Багийн бүрэлдэхүүн: 4 хүн – 1 толгой хүзүүний мэс заслын эмч, 1 нөхөн сэргээх мэс заслын эмч, 2 мэс заслын сувилагч Суралцсан улс, байгууллага: АНУ, NYU Langone Health Center Сургалтын хугацаа: 1 сар, 2025.02.10 - 2025.03.10
12.	Эгмээс дооших цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс заслын эмчилгээ	
13.	Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал: - Бага аарцаг, цээжний хананы байрлалтай хорт хавдар	
14.	Тархи нугасны хавдрууд, толгой хүзүүний дахисан хавдрын стернотомик туяа эмчилгээ	
Д.	Уушги судлал	
15.	Уушгины төрөлхийн гажгийн мэс заслын эмчилгээ	
Е.	Гэмтэл согог судлал	
16.	Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил, гэмтлийн мэс засал	Байгууллага: ГССҮТ Багийн бүрэлдэхүүн: 2 хүүхдийн гэмтэл согог заслын эмч Суралцсан улс, байгууллага: БНХАУ, ӨМӨЗО-ны Анагаахын ухааны их сургуулийн гэмтлийн эмнэлэг, БНХАУ-ын Сүжоу их сургуулийн гэмтлийн эмнэлэг, Хунан хүүхдийн эмнэлэг, Жишуйтаны хүүхдийн ортопед. Сургалтын хугацаа: 3 сар, 2024.10.24 – 2025.05.10

		➤ Суралцах чиглэл: Доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн согогууд, гэмтэлийн дараах шагайн үений тогтворгүйтэлийн үеийн мэс заслын эмчилгээ, доод мөчдийн дутуу хөгжил ясны хавдрын нөхөн сэргээх мэс засал Багийн бүрэлдэхүүн: 5 хүн – 4 доод мөчний гэмтэл согог мэс заслын эмч, 1 мэдээгүйжүүлгийн эмч Тайлбар: БНСУ, БНТУ-д тус чиглэлийн тохиолдол цөөн тул сургалт олгох боломжгүй гэсэн хариу өгсөн. БНЭУ-ын Маренго Ази эмнэлэг сургалтыг 2025 оны 01-р сарын 20-ний өдөр эхлүүлэх боломжтой гэж байсан боловч тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.
17.	Хүзүү, сээр, бүсэлхий нурууны нугас тасарсан хүнд гэмтлийн үеийн мэс засал	
18.	Хүзүү, сээр, бүсэлхий нурууны төрөлхийн хүнд хэлбэрийн мурийлт эмгэгийн мэс засал	Байгууллага: ГССҮТ Багийн бүрэлдэхүүн: 2 хүн - 2 мэс заслын эмч Суралцсан улс, байгууллага: БНСУ, Сунчинхян их сургуулийн Бучён эмнэлэг Сургалтын хугацаа: 12 сар, 2024.11.03-2025.11.02
Ё.	Эрхтэн шилжүүлэн суулгах	
19.	Донороос реципентэд ясны чөмөг шилжүүлэн суулгах	
20.	Зүрх, нойр булчирхай, гэдэс, уушги шилжүүлэн суулгах	
21.	Элэг шилжүүлэн суулгах дараах тохиолдолд: - артер, венийн судас болон цөсний замын анатомийн хэвийн бус бүтэцтэй, - резус бүлгийн үл тохирол, - 2 өөр донороос элэг шилжүүлэн суулгах.	

22.	Тунгалгийн судасны гаж хөгжлийн нөхөн сэргээх мэс засал /Зааны хөл гэмээр өөрчлөлт/	
Ж.	Эх барих, эмэгтэйчүүд, үргүйдэл судлал	
23.	Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний гаж хөгжлийн үе дэх нөхөн сэргээх мэс засал	
24.	Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн үеийн лазер эмчилгээ	
25	Үр хөврөлийг умайд суулгахаас өмнөх генетикийн оношилгоо	Тайваний “Chang Gung Memorial Hospital”-д суралцуулахаар тохирон сургалтыг 2024 оны 11-р сарын 18-ны өдөр эхлэхээр товлосон байсан боловч улс төрийн нөхцөл байдлаас үүдэн тус сургалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. Мөн багийн гишүүнийг 2 удаа сольж товлосон хугацаанд сургалтыг эхлүүлж чадаагүй тул сургалт хойшилсон. ЭХЭМҮТ-с БНХАУ-ын Ренжи эмнэлэгт сургалтыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг дэмжиж өгөх хүсэлтийг ирүүлсэн.

